

ПСИХОАНАЛИТИК ОНОЛ ДОХ НИЙГМИЙН АСУУДЛЫГ СУДЛАХ НЬ

М.Анара - Япон. Киото Их Сургууль. Хүн ба Орчин судлалын сургууль, докторант

Түлхүүр үг: хувь хүн, аз жаргал, бүлэг, бүлгийн сэтгэл зүй, би.

Психоаналитик онол нь хүний сэтгэл зүйн ертөнцийг түүний зохион байгуулалт, механизмаар дамжуулан тайлбарлаж, улмаар хүн өөрийн оршихуйг объектив ертөнцөөс харах явцад сэтгэл зүйд илрэх үзэгдлүүдийг шинжлэн судалдаг. Хүн өөрийгөө объектив ертөнцөөс харна гэдэг өдөр тутмын ойлголтонд ойлгомжгүй сонсогдох боловч, хүний сэтгэл зүйн ертөнд бол байнга болж байдаг энгийн үзэгдэл байж болох юм.

Өнөөдөр дэлхийн олон оронд энэ онол судлагдан, баримтлагдаж байна. Психоанализыг ерөнхийд нь психоаналитик онол ба практик хэрэглээ буюу эмчилгээний арга анализ гэсэн хоёр чиглэлээр хуваан ойлгож болно. Уг онолын нэг онцлог бол практик үйл ажиллагаан дээр суурилан хөгжсөн явдал юм. Психоанализыг эмчилгээний практик талаас салган, судалж эхлэхэд хэцүү гэж хэлж болно. Гэхдээ нөгөө талаас, зүүд тайлал, сэтгэл зүйн механизм, хүүхдийн өсөлт хөгжил зэрэг хүний амьдралд ойр, төсөөлөхөд хялбар судлагааны объектуудыг авч үздэг онол гэж бас ойлгож болно.

Хүн ертөнцөд бие махбод болоод сэтгэл зүрх гэгч нэгэн бүхлийг агуулан мэндэлдэг. Хүн төрсөн цаг мөчөөсөө эхлэн гэр бүл хэмээх бүлгийн (group) орчинд өсөж, улмаар нийгэм хэмээх хамгийн том бүлгийн дотор хувь хүн болж төлөвшдөг. Нийгэм нь хувь хүн болоод бүлгийн хоорондын харилцаан дээр тогтдог. Хувь хүн болгон бие биетэйгээ сэтгэл зүйн хувьд холбогдож нэгэн бүлэг болж нийгмийг бүрэлдүүлж байдаг. Иймд хувь хүний нийгэм дэх үйлдлийг ойлгохын тулд хувь хүний сэтгэл зүйн зохион байгуулалт, улмаар бүлгийн доторх харилцааг судлан үзэх шаардлагатай юм.

Энэ судлагааны ажлын гол зорилго бол З.Фройд ба З.Фройдос хойших үеийн эрдэмтдийн онолыг судласны үндсэн дээр психоаналитик онолд нийгэм болоод хувь хүний хоорондох холбоог хэрхэн авч үзсэнийг судлан шинжлэх юм.

Судлагааны ажил хоёр хэсгээс бүрдэж байгаа юм. Эхний хэсэгт хувь хүн ба бүлэг хүмүүсийн хоорондын харилцаа нь З.Фройдийн онолд хэрхэн туссан тухай юм. Энэ хэсэгт З.Фройдийн “Тэтем ба Табу”(1913), “Бүлгийн сэтгэл зүй болоод его-г задлан шинжлэх нь”(1923), “Соёл ба түүнд орших үл ханамж”(1930) гэсэн зохиолуудыг судласан болно. Эдгээр нь нийгмийн эх үндэс болоод түүний нөлөөг ойлгохыг зорилго болгосон бүтээлүүд гэж үзэж болох юм.

Дараагийн хэсэгт, Дэлхийн I дайнаас дэлхийн II дайн хүртлэх хугацаанд тухайн үеийн нийгмийн болоод шинжлэх ухааны өөрчлөлттэй холбон Фройдос хойших үеийн судлаачдын ‘үзэл санааг’ судласан болно. Тэдгээр дотороос ‘онцолж’ Английн М.Клайн, В.Бион, Америкийн Эрик Эриксоны үзэл санааг авч үзсэн болно.

Фройдийн онол дох нийгмийн асуудлаас

Орчин үед хүний өмнө тулгарч буй олон асуудлуудын нэг бол хүн нийгэмд хэрхэн хувь хүн болох, улмаар тухайн нийгэмтэйгээ сэтгэл зүйн хувьд хэрхэн харилцан холбогдож буй асуудал юм. Уг асуудлыг нийгэмд хувь хүн болох би ямар байр суурь эзэлж, ямар үүрэг гүйцэтгэж байна вэ гэсэн энгийн өнцгөөс харж болох юм. Улмаар уг асуудал нь нийгэм гэдэг зүйл маань чухам юу гэгч болох, би-би өөрөө хэн гэгч болох гэх мэт асуудлуудыг дараа дараагаар ургуулан гаргах нь дамжиггүй биз ээ.

Нийгэм сэтгэл зүйн онолын түүхэнд олон эрдэмтэд тухайн цаг үеийн бодит байдлыг тунгаан бодсоны үндсэн дээр дээрх асуудлуудыг өөрсдийн үзэл онолын үүднээс шийдвэрлэхийг оролдож байжээ. З.Фройдийн хувьд тэрээр нийгэм хүн хоёрын хоорондох харилцааг сөрөг талаас нь авч үзсэн юм. Тухайлбал, хүн нийгэмд аз жаргалгүй сэтгэл хангалуун бус байдаг хамгийн гол шалтгаан нь бусадтай нийгэмшсэн харилцаа холбоо аж. Түүний хэлсэнээр энэ бол “соёл ба түүнд орших үл ханамж”¹ юм. Гэвч З.Фройд ингэж үзсэнээрээ хүн нийгэмд аз жаргалтай байхыг үгүйсгэсэн хэрэг биш юм. Харин тэрээр “хүн дотоод ертөнц буюу сэтгэл зүрх болоод гадаад ертөнцийг холбох сэтгэл зүйн тэнхээ хүчтэй байх нь аз жаргалд хүрэх боломжийг агуулж байдаг. Бид аз жаргалыг объектив талаас хардаг. Үнэн хэрэгтээ энэ нь субъектив талаас буюу таашаалын зарчмын үүднээс мөн чанараа илэрхийлдэг юм. Иймд аз жаргал гэдэг бол хүн болгонд адил байх алтан дунджыг агуулдаггүй. Өөрөөр хэлбэл, хүн болгонд өөр өөрийн аз жаргал, түүнийг эдлэх таашаал оршиж байдаг” гэж үзсэн.

Бид нийгэмд соёлоор дамжиж бие биетэйгээ харилцан холбогддог. Гэвч хүний хүн хүндээ халдах хүсэл нь соёлд харшилж, улмаар түүнийг төвөггүй үргэлжлэхэд саад болж байдаг. З.Фройд үүнийг нийгэмдэх “өөрийн хөршөө өөрийгөө мэт хайрла” гэх зарчим нь хүний сэтгэл зүйтэй зөрчилдөхийг үл харгалзан, нийгэмд халдах хүслийг хязгаарлахын тулд баримтлах зарчим болсон² гэж тайлбарласан. Нийгмийн талаас үүнийг авч үзвэл, хүний дээрх бие биедээ халдах мөн чанарыг хязгаарлах үүргийг соёл гүйцэтгэдэг. Ингэхдээ, түүнийг түүний анхдагч эх үүсвэр болох сэтгэл рүү эргүүлэн буцаах сэтгэл зүйн процесс явагддаг байна.

Дүгнэх нь: З.Фройдийн дээрх үзэл санааг нэгтгэн дүгнэж үзвэл, хүн ба нийгмийн хоорондох харилцаа нь зөрчилдөөн дээр тогтож байдаг. Үүний гол шалтгаан нь хүмүүс хоорондын харилцаа аж. Гэвч хувь хүний сэтгэл зүйн тогтвортой, хүчтэй байдал нь нийгэмд орших нэг арга болж болохыг тэрээр хэлэхийг оролдсон байна.

¹ The Standard Edition of The Complete Psychological Works of Sigmund Freud. "The Future of an Illusion ; Civilization and its Discontents and Other Works". Volume XXI (1927-1931)

² The Standard Edition of The Complete Psychological Works of Sigmund Freud."The Future of an Illusion ; Civilization and its Discontents and Other Works". Volume XXI (1927-1931)

**Фройдос хойших үеийн психоаналитик
онолдох нийгмийн асуудлаас**

Психоанализын түүхэнд 1932 оноос Дэлхийн II дайныг дайран өнгөрөх үеэс эхлэн З.Фройдос хойших үеийн психоаналистуудын үе эхлэсэн гэж үздэг¹. Психоанализд энэ үеэс эхлэн хүнийг гэр бүл ба нийгэм гэсэн гадаад ертөнцийн сэтгэл зүйн орчин болоод бие махбодыг хослуулсан цэгээс авч үзэх болсон юм.

Мөн энэ үеийн психоаналистуудын дотор нео-фройдистууд гэж нэрлэгдэх Америк тивд судлагаа шинжилгээгээ төвлөрүүлэн явуулах болсон судлаач эрдэмтэд багтаж байгаа юм. Америк тив гэх шинэ ертөнц рүү цагаачлах болсон психоаналистуудыг, тэдний соёл, үндэс угсаа, амьдралын хэв маяг нь өөр өөрийн түүх болоод үнэлэмжээрээ ялгаатай байж, тэдгээр онцлог болоод ялгаагаа хадгалан авч үлдэх, эс бөгөөс түүнийгээ алдах аюулыг өөрсдийн биеэр туулж үзсэнээрээ бусад үеийн психоаналистуудаас ялгаатай байсан гэж онцолж үзэж болох юм.

Английн психоаналист Меланий Клайн (1882-1960) Австрийн Вени хотод төрсөн боловч Эрнест Жонсийн танилцуулгаар Лондон явж, тэнд насан эцэслэтэлээ судлагаа бүтээлээ туурвисан эмэгтэй юм. Тэрээр Английн Психоаналистын Холбоонд элсэж өөрийн үзэл онолоо боловсруулж, улмаар З.Фройдийн охин Анна Фройдтой үзэл онолын хувьд зөрчилдөж байсан, мөн психоанализын ертөнцөд бага насны хүүхдийн сэтгэл зүйг шинжлэн судласан эмэгтэй аналит гэдгээрээ алдартай юм. Тэрээр насанд хүрсэн хүний сэтгэл зүйн судлагаа, эмчилгээг бага насны хүүхдийн судлагаатай адил төвшинд авч үзэн судлахыг оролдсон.

Түүний судлагааны гол онцлог нь хүүхдийн сэтгэл зүйн хөгжилд фантаз буюу төсөөлж ургуулан бодох процессыг гол болгон судласанд оршино. Түүний үзлээр, бага насны хүүхдийн хувьд объектив харилцаа бол оюун ухаанд хадгалагдан үлдсэн өнгөрсөн үйл явдалтай шууд холбоотой аж. Өөрөөр хэлбэл, объектив харилцаа бол эцэг эх, цаашлаад хүн гэсэн нэгэн бүхэлтэй ухамсартайгаар харилцахын өмнөх үе буюу хөхөөр хооллох үе буюу биологийн мэдрэмж давамгайлсан үеэс эхэлдэг² аж.

Гэр бүл гэдэг ойлголт психоаналитик онолд чухал байр суурь эзэлнэ. Гэр бүл нь хувь хүний хөгжилтэй зайлшгүй холбоотой юм. Улмаар хувь хүн ба нийгмийн хоорондох холбоо нь гэр бүлээс урган гарна. XIX зууныг хүртэл бие хүний хувьд гэр бүлийн дотор өөрийн бодгал байдлыг тодорхойлж байсан бол XIX зуунаас эхлэн капитализм Европт хөгжиж эхэлсэнээр энэ хандлага өөрчлөгдөж эхэлсэн юм. Бие хүн өөрийн амьдралын туршлага болоод зорилгыг гэр бүлээс тусад нь тавьж үзэх болсон юм. Хувь хүний бодгал байдал нь хүн гэдэг ойлголтын үүднээс асуудал болон тавигдахын зэрэгцээ нийгмийн талаас хувь хүнд өгч буй зүйл нь түүний хэрэгцээг үл ханган зөрчилдөх болж эхэлсэн.

Гэр бүл нь хувь хүн болоод нийгмийн хоорондох харилцааг шийдвэрлэх явцад анхдагч институт байхаа больсон юм. Улмаар хувь хүн болоод гэр бүл нь судлагааны хувьд бие даасан объектууд болж эхэлсэн юм. Гэвч нөгөө талаас, хувь хүний нийгэм дэх

¹ 新宮一成『ラカンの精神分析』講談社現代新書、2007

² Melanie Klein. "The Psychoanalysis of Children". Volume 2, London Hogarth Press, 1984

байр суурийг судлахад сэтгэл зүйн төвшинд гэр бүл гэх элементийг орхих боломжгүй билээ. Иймд хувь хүний бие даасан амьдрал ингэж чухлаар тавигдах болсноор гэр бүлийн байр суурь буурсан гэж үзэж болохгүй. Харин ч зарим нэг тохиолдолд чухал болсон байж болох юм.

М.Клайны онолд хүүхдийн сэтгэл зүй нь түүний гэр бүл, цаашлаад хүүхэд эх хоёрын хоорондох харилцааг чухалчлан авч үздэг. Хүүхэд хөхөөр хооллох үеэс эхлэн ээжээрээ дамжин анхдагч объектив ертөнцтэй харилцаж эхэлдэг. Энэ үеийн харилцаа нь хүүхдийн ой санамжид хадгалагдан үлддэг байна.

Английн психоаналист В.Бионы (1897-1979) судлагааны гол сэдэв нь бүлгийн (group) тухай юм. Тэрээр бүлгийг нэг бүхэл механизм хэмээн үзэж, бүлгийн сэтгэл зүй гэсэн ойлголтоор тухайн бүлгийн оршихуйг тодорхойлж болно гэж үзсэн. Бүлгийн сэтгэл зүй нь тухайн бүлэг дэх гишүүдийн сэтгэл зүйгээс бүрэлдэнэ гэж үзэх юм бол энэ нь хувь хүмүүс нэг бүлэгт хамрагдан тухайн бүлгийн гишүүн болох үед хувь хүн байсан үеийн сэтгэл зүйгээсээ өөр сэтгэл зүйн үйлдэл, өөрөөр хэлбэл, бүлгийн сэтгэхүйд орлог юм. Бүлгийн гишүүд нэг бүрийн сэтгэл зүйгээр бүлгийн сэтгэл зүйг тодорхойлж болохгүй.

В.Бион бүлгийн сэтгэл зүй болоод хувь хүний сэтгэл зүйн хоорондох ялгааг тодорхойлохдоо “бүлгийн сэтгэл зүй гэдэг бол хувь хүнд хүсэл, үзэл бодлын зөрчилдөөн сэтгэл зүйн тайван бус байдал, бухимдал болоод сэтгэл зүйн бусад олон мэдрэмжийг төрүүлж болох юм.”¹ Учир нь бүлгийн доторх хувь хүн нь үл ухамсрын байдлаас бүлгийн сэтгэл зүйг бүрэлдүүлж байдаг юм. Бүлгийн механизм нь бүлгийн сэтгэл зүй болоод хувь хүний хүсэл шаардлагын дундаас хоёр талт үйлдлийн үр дүн болж явагддаг аж.

Орчин үеийн аль ч нийгэмд хувь хүний хувьд би-ийн (identity) тухай асуудал судлаач- эрдэмтдийн анхаарлыг татах болсныг үгүйсгэх аргагүй юм. Ялангуяа бие хүний хувьд бат тогтворжсон би-г эзэмшин орших нь чухал асуудал болж байгаа билээ.

Германы Франкфурт хотод төрсөн Эрик Эриксон (1902-1994) Америк тив рүү цагаачилж, улмаар шинэ нийгэмд өөрийн соёл, хувь хүн болох би-гээ алдах аюулыг өөрийн биеэр туулан гарсан хүн юм. Тэрээр дани эцэг, еврей гаралтай дани эх хоёрын дундаас төрж, еврейн нийгэм, шашны хүрээнээс ялгаварлан гадуурхагдаж, мөн герман гаралтнуудын комюнитигээс ч еврей хэмээн нүд үзүүлэгдсэний улмаас өөрийн би-гийн талаар хувь хүний хувьд сэтгэл зүйн зөрчилтэй байсан аж.

Энэ байдал түүнд үзэл онолоо боловсруулахад нь тодорхой нөлөө үзүүлсэн юм. Өөрийн хувийн амьдралд болсон энэ асуудлыг тэрээр онолынхоо голлох нэг сэдэв болгож судласан. Би-гийн тухай үзэл онолоо тусгасан түүний гол бүтээлүүдээс “Бага нас бийн нийгэм”(1950), “Эго-би”(1959) гэх мэтийг дурдаж болох юм. Психоаналитик онолыг үүднээс би-гийн тухай түүний онолыг авч үзвэл, З.Фрейдээс хойших үеийн эрдэмтдийн дотроос нийгмийн асуудлыг нэлээд чухлаар авч үзсэн онол гэж дүгнэж болох юм.

¹ Gerard Bleandonu. "Wilfred Bion: his life and works". The Guilford Press, New York, 1994.

Э.Эриксон, би-гийн тухай асуудал нь цаг үеийн өөрчлөлтөөс шалтгаална гэж үзсэн. Тухайлбал, түүний хэлснээр, З.Фройдын үед сэтгэл зүйн дарамт гэсэн сэдэв нь судлагааны гол объект байсан бол, өнөө үед орчин үеийн үйлдвэрлэлийн нийгмийн дотор хувь хүний хувьд “үндэсгүй” (uprootedness) гэсэн асуудал болж байна¹.

Э.Эриксоны үзэл санааг дараах байдлаар тайлбарлаж болно. Хүн нийгэмд өөрийн эхлэх цэг буюу өөрийгөө хэн бэ гэдгийг тодорхойлж, түүнийгээ хувь хүний хувьд нийгэмд өөрөө өөртөө итгэлтэй байх гэсэн сэтгэл зүйн байдалтай холбох хүслийг агуулж байдаг. Энэ нь бусдын нүдээр өөрийгөө харж, тодорхойлох би-тэй адилтган үзэх хүсэл байж болох юм. Яагаад гэвэл, хүн нийгэмд бусдаар хүлээн зөшөөрөгдсөн би-тэй байх нь үүний эсрэг тал болох цэвэр өөрийн би-тэй байхаас илүү өөртөө итгэх итгэлийг төрүүлдэггүй гэж үү.

Э.Эриксоны үзлээр, өөрийн би-тэй байна гэдэг бол ямар нэг юманд хүрэх процесстой адил биш юм. Учир нь би гэдэг нь хүний бүхий л амьдралын турш хөгжин, цэвших үйл явцын үр дүнд бүрэлдэн тогтдог төгсгөлгүй зүйл юм. Иймд би-тэй болно гэсэн эцсийн цэг гэж үгүй юм.²

Дүгнэх нь: Хүний сэтгэл зүйн хөгжилд М.Клайны үзсэнчлэн, түүний гэр бүл, олон угсаа эхтэй харилцах анхдагч харилцаа чухал байр суурь эзэлдэг аж. Энэ харилцаа нь буруу тавигдах, сэтгэл зүйн шарх болох үед бага насны хүүхдийн хүмүүжлийн доголдол, цаашлаад сэтгэл зүйн өвчний эх үүсвэр болж болох юм. Бүлгийн сэтгэл зүй нь бүлэг дэх гишүүдийн хувьд үл ухамсрын нөлөөгөөр бүрэлдэнэ гэсэн В.Бионы үзэл нь тухайн гишүүнд бүлэг дотор сэтгэл зүйн хувьд алслагдах буюу ганцаардах үзэгдлийг бий болгох боломжийг төрүүлж байгаагаараа сөрөг санаа агуулж байж болох юм. Гэвч нөгөө талаас, хувь хүний бүлэг дэх алслагдах байдлыг үл ухамсрын талаас тайлбарлах боломжтой гэж үзэж болох юм.

Би-ийн тухай асуудлыг олон эрдэмтэн судлаачид судлаж байгаагийн дотор Э.Эриксоны үзлээр, “би нь хүний амьдралын бүхэл үеийн турш бүрэлдэн тогтдог” гэж үзсэнээрээ онцлог юм.

Summary

In the contemporary world the one of the key issues of people as an individual living in a society becomes the problem of creating who they are, what they may become and how to make a sense of their life. Regarding to these issues, first of all we should study relationship between an individual and society.

Scholars, who are in the field of psychoanalysis, describe that psychoanalysis deals with the issues engaged with an individual and one of the great achievements of it was to break through the dichotomy existing between the individual and society. As Freud himself mentioned, “every human being is in its most profound expression could be understood only in relation to the other.”³ To understand any individual, we need to see him or her both as a biological and social being. Psychoanalysts since Freud placed greater emphasis on the ego that part of personality concerned with directing action, coping with the external world and integrating, competing urges within the self.

Erik Erikson. "Childhood and society". New York, 1950.

エリク・エリクソン『幼児期と社会』みすず書房、1977.

Dylan Evans "An introductory dictionary of Lacanian psychoanalysis" Routledge, 1996.pp.80

Amongst followers of Freud, 1).Erik Erikson is considered extending psychoanalytic thought in to trace the evolution of the ego throughout life, at the same time he remains within the essential spirit of Freud's approach. 2).Melanie Klein formulated her theory by studying the development of mental process of children. Her theory result says that for children their early recollection of childhood is the main key to understand their mental process.3).Regarding to the psychoanalytic theory of W. Bion ,the role of group is central to the understanding of the way in which institutions of society reflect individuals' underlying aims: the group is the key link between the individual and society.

Ном зүй

Англи хэлээр :

- C. Fred Alford. "Melanie Klein and Critical Social Theory". Yale University Press, 1989.
- Gerard Bleanodonu. "Wilfred Bion:his life and works".The Guilford Press, New York,1994.
- Erik Erikson."Childhood and society". New York, 1950.
- The Standard Edition of The Complete Psychological Works of Sigmund Freud. "Totem and Taboo and Other Works". Volume XVIII (1913-1914)
- The Standard Edition of The Complete Psychological Works of Sigmund Freud. "Group Psychology and Other Works". Volume XVII (1920-1922)
- The Standard Edition of The Complete Psychological Works of Sigmund Freud."The Future of an Illusion Civilization and its Discontents and Other Works". Volume XXI (1927-1931)
- Melanie Klein. "Love, Guilt and Reparation: And Other Works1921-1945". Volume 1, London Hogarth Press,1984.
- Melanie Klein. "The Psychoanalysis of Children". Volume 2, London Hogarth Press,1984.
- Melanie Klein."Envy and Gratitude". Volume 3, London Hogarth Press,1984.
- Melanie Klein."Narrative of Child Analysis". Volume 4, London Hogarth Press,1984.
- Richard Stevens ."Erik Erikson". The Open University Press, 1983.
- Richard Stevens ."Freud and Psychoanalysis". The Open University Press, 1983.
- Fred Weinstein."Freud, psychoanalysis, social theory". State University of New York Press, 2001.

Япон хэлээр:

- エリク・エリクソン『幼児期と社会』みすず書房、1977
- エリク・エリクソン『自我同一性』小此木啓吾、小川勝之訳、誠信書房、1974
- 『フロイト著作集3』高橋義孝 他訳、人文書院、1969
- 『フロイト著作集6』高橋義孝 他訳、人文書院、1969
- 『フロイト全集17』須藤訓任、藤野寛訳、岩波書店、2006
- 『フロイト全集18』本間直樹、家高洋、他訳、岩波書店、2007
- ビーター・ゲイ『フロイト』第1巻、鈴木晶訳、みすず書房、1988
- フィリップ・ジュリアン『ラカン、フロイトへの回帰—ラカン入門』向井雅明訳、誠信書房、2002
- L・グリンベルグ他『ピオン入門』高橋哲郎訳、1982
- 新宮一成『ラカンの精神分析』講談社現代新書、2007